



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Улиастай сумын Хүүхдийн 2 дугаар цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: ЗАА-2022/155/СТА-ТШЗ

Цахим хуудас:
www.audit.mn
Улиастай сум
2022 он

Завхан аймаг дахь Төрийн Аудитын газрын
тэргүүлэх аудитор: Д.Бат-Ундраа
Утас: 99993365
Цахим хаяг: Bat-Undraa@audit.gov.mn

Ахлах аудитор : Б.Дагвасүрэн
Утас:99014227
Цахим хаяг: dagvasurenb@audit.gov.mn

Аудитор Б.Жалбаа
Утас: 89330330
Цахим хаяг: jalbaab@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1. Аудитын санал дүгнэлт	2
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	4
3. Аудитын тайлан	10
3.1 Ерөнхий зүйл	10
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	10
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	11
3.4 Материаллаг байдал	11
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга	11
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	11
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг	12
3.8 Аудитын гол асуудал	12
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	12
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	13
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал	13
4. Аудитын илрүүлэлт	13
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	14

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар



УЛИАСТАЙ СУМЫН ХҮҮХДИЙН 2 ДУГААР ЦЭЦЭРЛЭГИЙН ЭРХЛЭГЧ С.ЮМЧМАА-Д

**ЗАВХАН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

81000 Улиастай, Завхан аймаг
Утас/Факс: 7046-36-12

додд. ор. д/л № 1902/56

танай _____ -ны д/л _____ -т

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Улиастай сумын Хүүхдийн 2 дугаар цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Улиастай сумын Хүүхдийн 2 дугаар цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

013022933

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Д.БАТ-УНДРАА

2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

СТ-1А

/мян.төгр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН		
35	БАРАА МАТЕРИАЛ	93,974.20	95,204.82
351	Түүхий эд материал	7,318.17	11,197.38
35110	Тусгай зориулалттай материал	6,366.40	10,022.20
35130	Эм боох материал	951.77	1,175.18
354	Хангамжийн материал	86,656.03	84,007.44
35410	Бичиг хэргийн материал	4,119.50	4,520.54
35420	Аж ахуйн материал	17,027.92	17,395.90
35440	Түлш, шатах тослох материал	0.00	558.40
35460	Хүнсний материал	13,312.00	9,290.98
35470	Бусад хангамжийн материал	52,196.62	52,241.62
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	993,275.05	977,158.08
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	993,275.05	977,158.08
392	Биет хөрөнгө	975,246.68	959,542.21
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,000,000.00	1,000,000.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-62,500.00	-79,166.67
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	49,751.69	58,328.49
39206	Хуримтлагдсан элэгдэл	-28,482.83	-34,141.29
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	30,953.91	34,606.81
39208	Хуримтлагдсан элэгдэл	-22,185.74	-26,437.28
39214	Бусад үндсэн хөрөнгө	23,525.18	23,525.18
39215	Хуримтлагдсан элэгдэл	-16,994.27	-18,351.77
39217	Ном	1,178.74	1,178.74
393	Биет бус хөрөнгө	18,028.38	17,615.88
39301	Програм хангамж	1,650.00	1,650.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-103.13	-515.63
39303	Бусад биет бус хөрөнгө	16,481.50	16,481.50
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	1,087,249.25	1,072,362.90
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	1,087,249.25	1,072,362.90
51	Засгийн газрын хувь оролцоо	1,087,249.25	1,072,362.90
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	52,465.75	52,465.75
51101	Өмч: - төрийн	52,465.75	52,465.75
512	Хуримтлагдсан үр дүн	1,032,668.39	1,017,782.04
51210	Өмнөх үеийн үр дүн	1,032,668.39	1,032,668.39
51220	Тайлант үеийн үр дүн	0.00	-14,886.35
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	2,115.11	2,115.11
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	1,087,249.25	1,072,362.90

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

СТ-2А

САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	276,108.68	480,909.39
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	0.00	3,580.00
120	Нийтлэг татварын бус орлого	0.00	3,580.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	0.00	3,280.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	0.00	3,280.00
120009	Бусад орлого	0.00	300.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	276,108.68	477,329.39
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	0.00	5,317.69
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	0.00	5,317.69
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	24,973.20	48,101.20
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	24,973.20	48,101.20
132006	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт / аймгаас авсан санхүүгийн дэмжлэг/	6,772.08	0.00
1330	Төсвийн захирагчдаас	251,135.48	423,910.50
133001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	244,363.40	423,910.50
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	238,535.59	495,795.74
21	УРСГАЛ ЗАРДАЛ	238,535.59	495,795.74
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	231,763.99	460,871.05
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	164,494.63	303,177.14
210101	Үндсэн цалин	106,623.21	197,338.42
210102	Нэмэгдэл	46,256.42	82,921.96
210103	Унаа хоолны хөнгөлөлт	265.00	565.80
210104	Урамшуулал	11,350.00	22,350.96
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	20,520.06	40,700.36
210201	Тэтгэврийн даатгал	13,940.28	28,610.81
210202	Тэтгэмжийн даатгал	1,628.24	3,075.13
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,332.66	2,443.38
210204	Ажилгүйдлийн даатгал	328.99	596.12
210205	Эрүүл мэндийн даатгал	3,289.89	5,974.91
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	22,381.64	46,713.20
210301	Гэрэл, цахилгаан	1,464.15	3,326.18
210302	Түлш, халаалт	19,150.56	38,440.72
210303	Цэвэр, бохир ус	1,766.93	4,946.30
2104	Хангамж, бараа материалын зардал	2,356.15	7,833.98
210401	Бичиг хэрэг	689.70	1,651.41
210402	Тээвэр, шатахуун	120.20	1,506.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	409.05	1,000.00
210404	Ном, хэвлэл	0.00	55.00

210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,137.20	3,621.57
2105	Нормативт зардал	7,031.74	31,554.31
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	0.00	2,548.49
210502	Хоол, хүнс	7,031.74	27,765.92
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	0.00	1,239.90
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	0.00	754.90
210604	Урсгал засвар	0.00	754.90
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	565.00	760.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	565.00	0.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	0.00	760.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	14,414.77	29,377.17
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	312.00	1,030.50
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	14,102.77	28,346.67
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	6,771.60	34,924.68
2132	Бусад урсгал шилжүүлэг	6,771.60	5,317.69
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	0.00	5,317.69
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	6,771.60	0.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	0.00	29,607.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	0.00	29,607.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	37,573.09	-14,886.35
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	37,573.09	-14,886.35

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

СТ-4А

ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

/ мян.төг /

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2013 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	52,465.75	2,115.11	1,054,155.33	1,108,736.20
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	52,465.75	2,115.11	1,054,155.33	1,108,736.20
C07	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	37,573.09	37,573.09
C08	2014 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	52,465.75	2,115.11	1,032,668.39	1,087,249.25
D01	2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	52,465.75	2,115.11	1,032,668.39	1,087,249.25
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	52,465.75	2,115.11	1,032,668.39	1,087,249.25
D08	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	-14,886.35	-14,886.35
D09	2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	52,465.75	2,115.11	1,017,782.04	1,072,362.90

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

СТ-2А

МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	468,671.88	477,629.39
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	0.00	300.00
120	Нийтлэг татварын бус орлого	0.00	300.00
120009	Бусад орлого	0.00	300.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	468,671.88	477,329.39
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	0.00	5,317.69
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	0.00	5,317.69
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	54,280.88	48,101.20
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	47,508.80	48,101.20
132006	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт / аймгаас авсан санхүүгийн дэмжлэг/	6,772.08	0.00
1330	Төсвийн захирагчдаас	414,391.00	423,910.50
133001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	414,391.00	423,910.50
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	467,021.88	468,679.69
21	УРСГАЛ ЗАРДАЛ	467,021.88	468,679.69
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	423,777.35	433,755.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	285,863.58	303,177.14
210101	Үндсэн цалин	190,532.02	197,338.42
210102	Нэмэгдэл	69,491.77	82,921.96
210103	Унаа хоолны хөнгөлөлт	710.20	565.80
210104	Урамшуулал	25,129.59	22,350.96
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	38,523.34	40,700.36
210201	Тэтгэврийн даатгал	26,386.01	28,610.81
210202	Тэтгэмжийн даатгал	3,091.63	3,075.13
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,403.28	2,443.38
210204	Ажилгүйдлийн даатгал	582.02	596.12
210205	Эрүүл мэндийн даатгал	6,060.40	5,974.91
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	43,733.08	47,337.60
210301	Гэрэл, цахилгаан	3,500.86	3,392.18
210302	Түлш, халаалт	35,907.30	38,999.12
210303	Цэвэр, бохир ус	4,324.92	4,946.30
2104	Хангамж, бараа материалын зардал	6,220.10	8,616.90
210401	Бичиг хэрэг	1,853.20	2,063.35
210402	Тээвэр, шатахуун	335.00	1,506.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	920.00	1,000.00

Улиастай сумын Хүүхдийн 2 дугаар цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд дүгнэлт өгөх аудитын тайлан

210404	Ном, хэвлэл	124.00	124.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,987.90	3,923.55
2105	Нормативт зардал	38,921.86	27,556.70
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	2,598.50	2,597.90
210502	Хоол, хүнс	31,087.36	23,718.90
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	5,236.00	1,239.90
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	0.00	754.90
210604	Урсгал засвар	0.00	754.90
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	6,709.00	960.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	6,559.00	0.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	0.00	960.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	150.00	0.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	3,806.40	4,651.40
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	3,806.40	4,651.40
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	43,244.53	34,924.68
2132	Бусад урсгал шилжүүлэг	6,772.08	5,317.69
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	0.00	5,317.69
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	6,772.08	0.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	36,472.45	29,607.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	36,472.45	29,607.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	1,650.00	8,949.70
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	1,650.00	8,949.70
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	1,650.00	8,949.70
2200	Дотоод эх үүсвэрээр	1,650.00	8,949.70
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	1,650.00	8,949.70
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	-1,650.00	-8,949.70

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

ТГ

/ мян.төг /

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	471,710.60	442,404.70
21	УРСГАЛ ЗАРДАЛ	471,710.60	442,404.70
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	471,710.60	442,404.70
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	315,817.30	303,177.14
210101	Үндсэн цалин	208,270.90	197,338.42

210102	Нэмэгдэл	84,695.40	82,921.96
210103	Унаа хоолны хөнгөлөлт	500.00	565.80
210104	Урамшуулал	22,351.00	22,350.96
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	42,635.20	40,700.36
210201	Тэтгэврийн даатгал	30,002.60	28,610.81
210202	Тэтгэмжийн даатгал	3,158.20	3,075.13
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,526.50	2,443.38
210204	Ажилгүйдлийн даатгал	631.60	596.12
210205	Эрүүл мэндийн даатгал	6,316.30	5,974.91
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	49,946.30	47,337.60
210301	Гэрэл, цахилгаан	6,000.00	3,392.18
210302	Түлш, халаалт	39,000.00	38,999.12
210303	Цэвэр, бохир ус	4,946.30	4,946.30
210304	Байрны түрээс	0.00	0.00
2104	Хангамж, бараа материалын зардал	8,616.90	8,616.90
210401	Бичиг хэрэг	2,153.20	2,063.35
210402	Тээвэр, шатахуун	1,506.00	1,506.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,000.00	1,000.00
210404	Ном, хэвлэл	124.00	124.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,833.70	3,923.55
2105	Нормативт зардал	37,657.90	27,556.70
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	2,598.40	2,597.90
210502	Хоол, хүнс	33,819.60	23,718.90
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,239.90	1,239.90
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	754.90	754.90
210604	Урсгал засвар	754.90	754.90
2107	Томилолт, зочны зардал	1,859.80	0.00
210702	Дотоод албан томилолт	1,859.80	0.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,115.90	960.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,115.90	960.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	13.31	13.30
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	13,306.40	13,301.10
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	0.00	29.61
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	471,710.60	472,011.70
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	421,009.40	423,910.50
131001	Улсын төсвөөс санхүүжих	421,009.40	423,910.50
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	50,701.20	48,101.20
132001	Орон нутгийн төсвөөс	50,701.20	48,101.20

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

НТ-2

НЭМЭЛТ САНХҮҮЖИЛТИЙН ТАЙЛАН

/ мян.төг /

Дансны код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН		6772.08
21	УРСГАЛ ЗАРДАЛ		6772.08
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		6.77208
2132	Бусад урсгал шилжүүлэг		6772.08
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг		6772.08
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР		6.77208
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого		6772.08
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		6772.08

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Улиастай сумын Хүүхдийн 2 дугаар цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд нягтлан бодох бүртгэл, тайлагнал, худалдан авалт, арвилан хэмнэлт зэрэгтэй холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Завхан аймаг дахь Төрийн Аудитын газрын аудитор Б.Жалбаа гүйцэтгэж, хяналтыг ахлах аудитор Б.Дагвасүрэн, дарга, тэргүүлэх аудитор Д.Бат-Ундраа нар хэрэгжүүлсэн.

Улиастай сумын Хүүхдийн 2 дугаар цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Завхан аймаг дахь Төрийн Аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 17-ний өдрийн 02 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Улиастай сумын Хүүхдийн 2 дугаар цэцэрлэг нь “Бага насны хүүхдийг өөрийн онцлог, чадвар, бүтээлч үйлээрээ хөгжин, насан туршийн боловсролын суурь чадварыг эзэмшихэд дэмжин асрах, хамгаалах, хөгжүүлэх, сургалт, үйл ажиллагаагаар сургуулийн өмнөх боловсрол эзэмшүүлэх” гэсэн зорилтын хүрээнд үйл ажиллагааг явуулж байна

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна гэж үзлээ.

Тус байгууллага нь Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг болон дотоод хяналтыг хэрэгжүүлэх журам, заавар зэргийг боловсруулж мөрдсөн байна.

Дотоод аудитын чиг үүрэг бүхий нэгж тус байгууллагад байхгүй байна.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Улиастай сумын Хүүхдийн 2 дугаар цэцэрлэг нь 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт орлогыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны нийт орлого 480.9 сая төгрөгийн 1 хувь буюу 4.8 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувь буюу 3.4 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитаар хянаж үзээд дахин өөрчлөх шаардлагагүй гэж үүлээ.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

/мянган төгрөг/

Үзүүлэлт Б	Эхний үлдэгдэл 1	Эцсийн үлдэгдэл 2	Өөрчлөлт 3=2-1
Авлага	0.00	0.00	0.00
Бараа материал	93,974.20	95,204.80	1,230.60
Үндсэн хөрөнгө	993,275.10	977,158.10	-16,117.00
Нийт хөрөнгө	1,087,249.30	1,072,362.90	-14,886.40
Өр төлбөр	0.00	0.00	0.00
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	1,087,249.30	1,072,362.90	-14,886.40
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	1,087,249.30	1,072,362.90	-14,886.40

Бараа материал дансны үлдэгдэл 95.2 сая болж өссөн нь номыг бараа материалаар тусгасан, хүүхдийн тоглоом худалдан авсан зэрэгтэй холбоотой байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 977.2 сая төгрөг болж буурсан нь элэгдлийн зардал болон багш хөгжлийн төвийг тохижуулж хөрөнгө бэлтгэсэнтэй холбоотой байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 1,072.4 сая төгрөг болж буурсан нь хуримтлагдсан үр дүн 14.9 сая төгрөгөөр буурсантай холбоотой байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Дээд шатны төсөв захирагч тус байгууллагын 2021 оны төсвийн зарлагыг 471.7 сая төгрөгөөр, санхүүжүүлэх эх үүсвэрийг тусгай зориулалтын шилжүүлгээс 421.0 сая, орон нутгийн төсвөөс 50.7 сая төгрөгөөр санхүүжүүлэхээр баталсан байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Гүйцэтгэлээр тусгай зориулалтын шилжүүлгээс 423.9 сая төгрөгийн, орон нутгийн төсвөөс 48.1 сая төгрөгийн, нийт 472.0 сая төгрөгийн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагааны зардалд 442.4 сая төгрөгийг зарцуулж, улсын төсөвт 29.6 сая төгрөгийг төвлөрүүлжээ.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд 6.8 сая төгрөгийн орлого бүрдүүлсэн бөгөөд энэ нь дээд шатны төсөв захирагчаас хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажиллаж байгаа алба хаагчдын мөнгөн урамшуулалд зориулан олгосон санхүүжилт байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Тус байгууллагын үйл ажиллагаанд онцолж үзэх асуудал байхгүй байна.

3.8 Аудитын гол асуудал

Тус байгууллага нь санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Байгууллагын үйл ажиллагааны зардал болох хүнсний материалыг нийлүүлэх бэлтгэн нийлүүлэгчийг сонгон шалгаруулж гэрээ байгуулсан байдлыг санхүүгийн аудитаар шалгахад материаллаг алдаа зөрчилтэй асуудал илрээгүй.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 149 мэдээллээс 147 мэдээллийг шилэн дансны цахим хуудсанд хугацаанд нь байршуулж, 2 мэдээллийг хугацаа болоогүй байна. Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт 98.6 хувьтай байна.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хуульд заасан хугацаанд НББ-ийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлэн тайлагнаж Төрийн аудитын газарт ирүүлсэн байна.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар зөвлөмж өгөгдөөгүй байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар авч үзэх материаллаг эрсдэлтэй асуудал ажиглагдаагүй болно.

4. Аудитын илрүүлэлт

Санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд дүгнэлт өгөх аудитаар нийт 4.8 сая төгрөгийн зөрчил илэрсэн байна.

4.1 Залруулсан алдаа

Санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд дүгнэлт өгөх аудитаар залруулах алдаа зөрчил илрээгүй болно.

4.2 Төлбөрийн акт

Санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд дүгнэлт өгөх аудитаар төлбөрийн акт тогтоох алдаа зөрчил илрээгүй болно.

4.3 Албан шаардлага

Санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд дүгнэлт өгөх аудитаар албан шаардлага өгөх алдаа зөрчил илрээгүй болно.

4.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Нягтлан бодох бүртгэл, тайлагналтай холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт:

Гэрэл цахилгааны зардлаас урсгал засварын зардалд, эмийн зардлаас бага үнэтэй түргэн элэгдэх зүйлсийн зардалд зориулалт бус зарцуулсан 1,148.5 мянган төгрөгийн зөрчил байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах” гэсэн заалт болон санхүүгийн тайлангийн нийцсэн бөгөөд зохистой байх гэсэн батламж мэдэгдэлтэй нийцэхгүй байна.

1.2. Өгсөн зөвлөмж:

Төсвийн зардлыг Сангийн сайдын 2021 оны 190 дугаар тушаалаар батлагдсан “зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар”-ын дагуу зарцуулж, тайлагнах

2. Дотоод хяналт хариуцлагатай холбоотой

2.1. Илрүүлэлт:

Халаалтын гэрээ байгуулан ажиллаж буй компани нь тайлант хугацаанд НӨАТ-ын баримтаа шивээгүй дараа онд шивсэн байна.

Энэ нь Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.3.1 “албан татвар төлөгчийн хийсэн төлбөр тооцооны мэдээллийг хэрэглэгчийн системд төлбөр хийсэн тухай бүр бүртгэнэ”, 17.3.2 “бараа, ажил, үйлчилгээг борлуулсан тухай бүр төлбөрийн баримтыг татвар төлөгчид олгоно”, НББ-ийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7 “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно” гэсэн заалт болон санхүүгийн тайлангийн тохиолдсон байх, толилуулга, нийцсэн бөгөөд зохистой байх гэсэн батламж мэдэгдэлтэй нийцэхгүй байна.

2.2. Өгсөн зөвлөмж:

Харилцагч байгууллагад төлсөн мөнгөний НӨАТ-ын баримтыг тухай бүр авч нэгдсэн системд бүртгэж, харин харилцагч байгууллага НӨАТ-ын баримтыг олгоогүй нөхцөлд харьяа татварын албанд нэн даруй мэдэгдэж баримтыг гаргуулан авах арга хэмжээг авч ажиллах

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

Д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Улиастай сумын Хүүхдийн 2 дугаар цэцэрлэг	2	4.9							2	4.9

БОЛОВСРУУЛСАН:

АУДИТОР

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АХЛАХ АУДИТОР



Б.ЖАЛБАА

Д.БАТ-УНДРАА

Б.ДАГВАСҮРЭН

2022.02.21